



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/НЗ

Булган сум

**Хэлний бодлогын салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хэлний бодлогын салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг хөгжүүлэх, хамгаалах үндсэн үүрэг бүхий "Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. "Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарч байгаатай холбогдуулан 2021 оны А/12 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2024 оны
14 дүгээр сарын 20-ны өдрийн 14.10.20 дугаар
захирамжийн хавсралт



**ХЭЛНИЙ БОДЛОГЫН ОРОН ТООНЫ БУС САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: Боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
- Зөвлөлийн гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Насан туршийн суралцахуйн төвийн захирал
- 1-р сургуулийн монгол хэлний багш, тэргүүлэх
- 1-р сургуулийн монгол хэлний багш, заах арга зүйч
- 2-р сургуулийн монгол хэлний багш, тэргүүлэх
- 3-р сургуулийн монгол хэлний багш, тэргүүлэх